




Орхон аймаг дахь Төрийн аудитын газар

ОРХОН АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨЛД САНАЛ ДҮГНЭЛТ ӨГӨХ
Аудитын код: ОРА-2025/07-13-ШТА-НА

АУДИТЫН ТАЙЛАНГААС



ОРХОН АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ



Улсын төсөвт 92.6 тэрбум ₮ төвлөрүүлж, зээлийн эргэн төлөлтөд 2.7 тэрбум ₮ төлнө.

ОРХОН АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН БОЛОН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.



Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь Засаг даргын 2024-2028 оы үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байдал

2026 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Орон нутгийн хөрөнгө оруулалт

- хөрөнгө оруулалт - 178.4 тэрбум ₮
- Төсөл, хөтөлбөр - 19.0 тэрбум ₮

Авто замын сан

- хөрөнгө оруулалт - 3.1 тэрбум ₮



Байгаль хамгаалах сан

- хөрөнгө оруулалт - 4.4 тэрбум ₮
- Төсөл, хөтөлбөр - 0.2 тэрбум ₮

Орон нутгийн хөгжлийн сан

- хөрөнгө оруулалт - 17.6 тэрбум ₮



АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫГ 0.6 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР, ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 1.3 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР НИЙТ 1.9 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.



Орон нутгийн төсвийн орлого 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 335.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 221.4 тэрбум төгрөг төвлөрч **гүйцэтгэл 60.0 хувьтай байна.**

Орлого нэмэгдүүлэх боломжуудаас

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 2025 оны 10 сарын байдлаар 1.9 тэрбум төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл 2.3 тэрбум төгрөгөөр тооцоолж, мөн авто машины тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа зэргээс шалтгаалан орлогыг 0.4 тэрбум төгрөгөөр, Торгуулийн орлого 2024 онд 0.3 тэрбум төгрөг, 2025 оны 10 сарын гүйцэтгэлээр 0.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэн тул 0.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ 5.2 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

Өмнөх онуудын төсвийн гүйцэтгэл, нэмж төлөвлөсөн зардлын хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах төсөв, хүрэх үр дүнг тооцоолоогүй зэргээс шалтгаалан аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн зарлагыг 3.9 тэрбум төгрөгөөр, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны төсвийн төслийн зардлаас 1.2 тэрбум төгрөгөөр бууруулах боломжтой байна.

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАХ-Г ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДОЛ, УРСГАЛ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ, СУДАЛГААГҮЙ ТӨЛӨВЛӨСӨӨР БАЙНА.

Орон нутгийн төсвийн төсөлд 2026 оноос эхлэн хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын 119 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 17 ТАХ нь сүүлийн хоёр жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөв, төсөлтэй байх төсөвлөлтийн шаардлага хангасан байхаар боловч 6 төсөл, арга хэмжээний зураг төсөвт магадлалаар баталгаажуулаагүй байна

ТӨСВИЙН ТӨСӨЛД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТАХ-НИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛД ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ 14 ТАХ-Г ТУСГАСАН БАЙНА.

Зөвлөмж. Засаг даргад:

- Зураг, төсөвгүй 6 төсөл, арга хэмжээг 2025 оны 12 сарын 25-ны дотор магадлалаар баталгаажуулах
- Шинээр хэрэгжих 14 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсвийн жил эхлэхээс өмнө боловсруулах.